



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 10 сарын 23 өдөр

Дугаар Б/30

Баянхутаг сум

Урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, 52 дугаар зүйлийн 52.1, 52.2, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, 2023 оны 442 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1.2, 1.2.2, 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын Байгаль, орчны хяналтын Улсын байцаагч Л.Энхцэцэгийн 2024 оны 3-р улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн урамшуулал олгосугай.

2. Үр дүнгийн урамшуулалыг үндсэн цалингийн 50 хувиар тооцон олгохыг Нягтлан бодогч (Г.Пүрэвдулам)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Б.ЗОЛБОО